



ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Ховд аймгийн Дарга, Тэргүүлэх
аудитор Л.Галбадрах
Утас: 70433061

Цахим хаяг:
galbadrakh.l@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545

Цахим хаяг:
tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Нарантуул
Утас: 70433061
Цахим хаяг:
Narantuul.d@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Ховд аймаг дахь
Төрийн Аудитын газар
Байршил: Аймгийн ЗДТГ-ын байр
3 давхар
Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64000 Цамбагаравь баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА А. БУРМАА ТАНАА

2018-02-09 № 2/30
танай _____-ны № _____ -1

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Булган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, шилэн дансны хуулийн дагуу дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй, хагас жилийн санхүүгийн тайлан, батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, түүний хэмнэлт хэтрэлтийн шалтгааны мэдээллийг мэдээллээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн тайлангийн ЭҮ,ИБ,Ү,ТИ,ҮЗ гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Булган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



A handwritten signature in black ink, consisting of stylized cursive letters, is written over a faint pink rectangular stamp. The signature is positioned to the right of the text 'ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР' and to the left of the name 'Л. ГАЛБАДРАХ'.

Л. ГАЛБАДРАХ

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Ховд аймгийн Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ХОА-/2018/11-СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Тус байгууллага нь 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ховд аймгийн Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 8-наас 2018 оны 2 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Тус байгууллагын төсвийн шууд захирагч нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 08-нд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Ховд аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 08-наас 2018 оны 2 дугаар сарын 9-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 9-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн газар нь 2017 онд “сумын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, өгөөжийг тогтвортой дээшлүүлэх, сумын эдийн

засаг, нийгмийн ногоон хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх, орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлж үр ашгийг дээшлүүлэх, хүний хөөцийн удирдлагын манлайллыг хангах, сургалт зохион байгуулах талаарх стратеги болон бүтцийн загварыг тодорхойлох”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадварлаг, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлж иргэдийн оролцоотой эдийн засаг, нийгмийн ногоон хөгжлийн хүрээнд уламжлал-шинэчлэлийн уялдааг ханган олон тулгуурт эдийн засгийн болон хүний хөгжлийг дэмжсэн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж олон үндэстэн, ястан ард түмний аж амьдралыг дээшлүүлэн ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдүүлэхэд оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу тус байгууллагын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аймгийн Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны төсвийг орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага тул Ховд аймгийн төрийн сангаас олгож байна.

Байгууллагын төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Сонгуулийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын төрийн албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайланг хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарааргүй байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, 2 сорилуудыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн ХНХЯ-наас гаргасан баримт бичиг ашиглан мөрдөж байна.

Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу шэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн "Accolus" програм хангамж ашиглажээ.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Төсвийн шууд захирагчийн байгууллагын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн шууд захирагч өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 51.4 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

д/д	Үзүүлэлт	Тайлант оны		/ сая.төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00	00	0	0
1	1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51.4	53.2	103.6	1.8
1.1	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	51.4	53.2	103.6	1.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51.4	53.2	103.6	1.8
2.1	ТШЗ-ЫН САНХҮҮЖИХ	51.4	53.2	103.6	1.8
2.2	Өөрийн орлого	-	-	-	-

Тайлант хугацаанд төсөвт байгууллага 51.4 сая төгрөгийн батлагдаж орон нутгийн төсвөөс 51.4 сая төгрөгний санхүүжилт батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж төсвийн санхүүжилтийг 53.2 сая төгрөгний орлого бүрдүүлжээ.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

Шилэн дансны мэдээлэл

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад хуульд заасан мэдээлэлийг тогтоосон хугацаанд хагас жилийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, түүний хэмнэлт хэтрэлтийн шалтгааны мэдээллийг оруулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан 4 горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний тайлант оны орлого, зарлагын гүйлгээг Аймгийн төрийн сангаас авч ерөнхий журналаас түүвэрлэлт хийж, анхан шатны баримттай тулган 1 дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тайлант онд 51.4 сая төгрөгний төсөв батлагдаж гүйцэтгэлээр 53.2 сая төгрөгний санхүүжилт олгож батлагдсан төсвийг 1.8 сая төгрөгөөр төсвөө хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийг мөрдөн ажиллах зөвлөмж өгөх,

2. Тус байгууллага нь сар бүрийн төсвийн гүйцэтгэл, түүний хэмнэлт хэтрэлтийн шалтгаан, хагас жилийн тайлан баланс, дараа жилийн төсвийн төсөл, батлагдсан төсвийн мэдээллийг мэдээллээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-д “ дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 16-ны өдрийн дотор”, 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны хуулийн дагуу холбогдох мэдээллийг бүрэн мэдээллэх зөвлөмж өгөх,

3. Жолоочийн тооцооны хуудсанд км-ийг тарифаас илүү бичсэн, хотын дотор тогтоолд заасан км-ээс илүү зарцуулсан 0.3, сумын ИТХ-ын хуралдаанд тушаал шийдвэргүй 0.6 бүгд 0.9 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 349 дүгээр тогтоолын 2 -д “албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоногт дундажаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашины хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дундажаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дундажаар 70 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөөлдөр бус анхан

шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийхгүй байх, холдогдох тогтоол, журмын заалтуудыг мөрдөн ажиллах зөвлөмж өгөх

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 2.7 сая төгрөгний алдааг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгах асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аймгийн Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 2.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэр хамрагдсан тул зөвлөмж өгөгдөөгүй.

Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ховд аймгийн Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, шилэн дансны хуулийн дагуу дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй, хагас жилийн санхүүгийн тайлан, батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, түүний хэмнэлт хэтрэлтийн шалтгааны мэдээллийг мэдээллээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-д “ дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 16-ны өдрийн дотор”, 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 8 дугаар

сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

3.МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь аймгийн Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Асуудал Шатахууны зарцуулалт,
анхан шатны баримт бүрдүүлэлт

Тэргүүлэх ач холбогдол №01

Илрүүлэлт

Жолоочийн тооцооны хуудсанд км-ийг тарифаас илүү бичсэн, хотын дотор тогтоолд заасан км-ээс илүү зарцуулсан 0.3 сумын ИТХ-ын хуралдаанд тушаал шийдвэргүй 0.6 бүгд 0.9 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 349 дүгээр тогтоолын 2 -д "албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоногт дундажаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашины хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дундажаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дундажаар 70 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэх" гэсэн заалтыг мөрдөөгүй байна

Эрсдэл

Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байх, зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

Зөвлөмж

ЗГ-ын тогтоол болон НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах

Хариуцах ажилтан

Байгууллагын дарга А.Бурмаа
Ня-бо Ш.Азжаргал

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.1 Асуудал 2 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Тэргүүлэх ач холбогдол №02

Илрүүлэлт

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянахад хуульд заасан тухайн жилийн батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн тайлан, сар бүрийн төсвийн хэмнэлт хяналтын мэдээлэлийг тогтоосон нугацаанд оруулаагүй байна. ¹

Зөвлөмж

Шилэн дансны хуулийг хэрэгжилтийг ханган ажиллах

Хариуцах ажилтан

Байгууллагын дарга А.Бурмаа
Ня-бо Ш.Азжаргал

¹ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, өмнө жилийн хэргэлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.3-д " дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 16-ны өдрийн дотор", 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа

Эрсдэл

Холбогдох заавар журмыг мөрдөөгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.1 Асуудал 3 Батлагдсан төсөв

Тэргүүлэх ач холбогдол №03

Илрүүлэлт

Тайлант онд 51.4 сая төгрөгний төсөв батлагдаж гүйцэтгэлээр 53.2 сая төгрөгний санхүүжилт олгож батлагдсан төсвийг 1.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Зөвлөмж

Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг явуулах

Хариуцах ажилтан

Байгууллагын дарга А.Бурмаа
Ня-бо Ш.Азжаргал

Эрсдэл

Холбогдох заавар журмыг мөрдөөгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЗЭГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	100,510.36
39	АВЛАГА	00.00	100,510.36
39100	Ажиллагсадтай холбогдсон авлага	00.00	100,510.36
2	ЗЭГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,301,919.96	2,609,999.92

Тайлан 4-дугаар сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор, 6.1.6-д "төсвийн гүйцэтгэл, хяналт, түүний шалтгааны тайлбар"

39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,301,919.96	2,609,999.92
392	Биет хөрөнгө	1,301,919.96	2,609,999.92
39205	Машин, тоног төхөөрөмж	6,919,000.00	8,119,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,776,749.96	-6,388,999.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,600,000.00	2,400,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,440,000.08	-1,520,000.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,301,919.96	2,710,510.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4,067,721.83	127,672.19
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,067,721.83	127,672.19
413	Өглөг	4,067,721.83	127,672.19
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг	3,829,019.83	127,672.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	-2,765,801.87	2,582,838.09
51	Засгийн газрын хувь оролцоо	-2,765,801.87	2,582,838.09
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	15,700,000.00	15,700,000.00
51101	Өмч -Төрийн өмч	15,700,000.00	15,700,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-18,465,801.87	-13,117,161.91
51210	Өмнөх үеийн үр дүн	-18,465,801.87	-18,226,769.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	5,109,607.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,301,919.96	2,710,510.28

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	50,752,000.00	53,292,627.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,752,000.00	53,292,627.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,752,000.00	53,292,627.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,752,000.00	53,292,627.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	54,339,863.79	48,183,019.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,339,863.79	47,283,019.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,339,863.79	47,283,019.04
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	42,529,897.27	37,196,320.00
210101	Цалин	42,529,897.27	37,196,320.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,678,288.56	4,097,949.00
210201	Тэтгэрийн даатгалын шимтгэл	2,977,092.72	2,607,784.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	340,239.17	325,245.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	425,298.96	345,330.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	85,059.79	74,509.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	850,597.92	745,081.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,062,698.00	3,818,300.00
210401	Бичиг хэргийн материал	979,324.00	899,000.00
210402	Тээвэр, шатахууны зардал	4,083,374.00	2,523,800.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	00.00	395,500.00
2107	Томиллолт, зочны зардал	386,400.00	562,200.00
210702	Дотоод томилолтын зардал	386,400.00	562,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	90,000.00	128,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	00.00	80,000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	48,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,592,579.96	1,480,250.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	100,000.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	512,500.00	688,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,080,079.96	692,250.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	00.00	900,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-3,587,863.79	5,109,607.96
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	-3,587,863.79	5,109,607.96

4.3 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
001	2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	15,700,000.00	00.00	-12,677,556.96	3,022,443.04
003	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,700,000.00	00.00	-12,677,556.96	3,022,443.04
007	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	00.00	00.00	-2,230,381.12	-2,230,381.12
001	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,700,000.00	00.00	-18,465,801.87	-2,765,801.87
002	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	239,032.00	239,032.00
003	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,700,000.00	00.00	-18,226,769.87	-2,526,769.87
008	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	00.00	00.00	5,109,607.96	5,109,607.96
009	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,700,000.00	00.00	-13,117,161.91	2,582,838.09

4.4 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	50,752,000.00	53,292,627.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,752,000.00	53,292,627.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,752,000.00	53,292,627.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,752,000.00	53,292,627.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	50,752,000.00	51,292,627.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,752,000.00	51,292,627.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,752,000.00	50,392,627.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	41,035,850.00	40,238,501.00
210101	Үндсэн цалин	34,820,962.00	30,527,811.00
210102	Нэмэгдэл	743,784.00	9,710,690.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	3,360,062.00	4,857,626.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	3,360,062.00	3,091,216.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	00.00	441,602.00

210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	00.00	353,283.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	00.00	88,320.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	00.00	883,205.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,367,188.00	3,537,300.00
210401	Бичиг хэрэг	814,324.00	618,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,427,864.00	2,523,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	125,000.00	395,500.00
2107	Томилолт, зочны зардал	386,400.00	562,200.00
210702	Дотоод албан томилолт	386,400.00	562,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,000.00	315,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	90,000.00	187,650.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	48,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	512,500.00	881,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	208,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	512,500.00	673,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	00.00	900,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	00.00	2,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	00.00	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	2,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,000,000.00
220001	Төног төхөөрөмж	00.00	2,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	00.00	-2,000,000.00

5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Зөрийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,752,000	50,752,000	51,451,200	53,292,627
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	50,752,000	50,752,000	51,451,200	53,292,627
210	Бараа, үйлчилгээний зардал	50,752,000	50,752,000	48,551,200	50,392,627
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,820,100	4,135,850	39,040,300	40,238,501
210101	Үндсэн цалин	38,820,100	34,820,962	28,139,500	30,527,811
210102	Нэмэгдэл	00	743,784	10,900,800	9,710,690
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,270,300	3,360,062	4,294,400	4,857,626
210201	Тэтгэврийн даатгал	2,717,500	3,360,062	4,294,400	4,857,626
2104	Хангамж, бараа материалын зардал	5,241,000	4,994,188	3,047,300	3,537,300
210401	Бичиг хэрэг	348,000	814,324	296,000	618,000
210402	Тээвэр (шатахуун)	4,475,400	4,054,864	2,351,300	2,523,800

210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	417,600	125,000	400,000	395,500
2107	Томилолт, зочны зардал	1,064,100	386,400	812,700	562,200
210702	Дотоод албан томилолт	00	00	812,700	562,200
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	394,000	00	394,000	315,650
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	80,000	00	80,000	80,000
210803	Даатгалын үйлчилгээ	85,000	90,000	85,000	00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	15,000	00	15,000	00
210806	Мэдээллийн технологийн зардал	00	00	166,000	187,650
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00	00	48,000	48,000
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	962,500	512,500	962,500	881,350
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	962,500	512,500	212,500	208,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00	00	750,000	673,350
2132	Бусад урсгал шилжүүлэг	00	00	900,000	900,000
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	00	00	900,000	900,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00	00	2,000,000	2,000,000
2200	Дотоод эх үүсвэрээр	00	00	2,000,000	2,000,000
222001	Тоног төхөөрөмж	00	00	2,000,000	2,000,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,752,000	50,752,000	51,451,200	53,292,627
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,752,000	50752000	51,451,200	53,292,627
131001	Улсын төсвөөс санхүүжих	50,752,000	50752000	51,451,200	53,292,627
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	03	03	03	03
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	01	01	01	01
620003	Үйлчлэх ажилтан	01	01	01	01

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

Огноо:2018. 02.09

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Огноо:2018.02.09

АУДИТЫН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

Огноо:2018.02.09